



УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

**ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС  
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ГИШҮҮНИЙ  
ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2023 ОНЫ ТАЙЛАНД ХИЙСЭН  
ШИНЖИЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА**

Улаанбаатар хот  
2024 он

## АГУУЛГА

### УДИРТГАЛ

#### **НЭГ.ХУУЛЬД ЗААСАН ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРХЭН ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАСАН ТАЛААР ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ**

1.1.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хяналт, шинжилгээ хийх чиг үүргийн хэрэгжилт

1.2.Олон нийтэд эрүү шүүлтийн хор аюулыг тайлбарлан таниулах, эрүү шүүлтээс ангид байх эрхийг төрийн албан тушаалтан, иргэдэд сурталчлах чиг үүргийн хэрэгжилт

1.3.Судалгаа хийх, ном, сургалт, сурталчилгааны хэрэглэгдэхүүн, сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах, хамтын ажиллагааг бэхжүүлэх, хамтран ажиллах чиг үүргийн хэрэгжилт

1.4.Хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл, сурталчилгаа тогтмол явуулах чиг үүргийн хэрэгжилт

1.5.Иргэн, албан тушаалтнаас ирүүлсэн эрүү шүүлтээс ангид байх эрх зөрчигдсөн талаарх гомдол, мэдээллийг холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлсэн талаар

#### **ХОЁР.ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ГИШҮҮНИЙ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ**

### ГУРАВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

**ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ  
АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ГИШҮҮНИЙ ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2023 ОНЫ ТАЙЛАНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭНИЙ  
ТАНИЛЦУУЛГА**

**УДИРТГАЛ**

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэгт заасны дагуу Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдөр Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2023 оны тайлангаа Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд ирүүлжээ.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн нь холбогдох хууль тогтоомжийн хүрээнд 2023 онд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар дараах сэдвийн дагуу тайланг боловсруулсан байна. Үүнд:

1. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хууль, эрх зүйн орчны шинэтгэл;
2. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хяналт, шинжилгээ;
3. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа;
4. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг бэхжүүлэх чиглэлээр;
5. Иргэн, албан тушаалтнаас ирүүлсэн эрүү шүүлтээс ангид байх эрх зөрчигдсөн талаарх гомдол, мэдээллийг холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлсэн талаар хийгдсэн ажил зэрэг болно.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.3 дахь хэсэгт заасны дагуу Хүний эрхийн Үндэсний Комисс (цаашид “ХЭҮК” гэх)-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2023 оны тайланд шинжилгээ хийлээ.

Тайланд шинжилгээ хийхдээ Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн нь Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 33-34 дүгээр зүйлд заасан чиг үүрэг, бүрэн эрхээ хэрхэн хэрэгжүүлэн ажилласан талаар Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийг удирдлага болгон баримт бичгийн дүн шинжилгээ хийх арга зүйг ашигласан болно.

## **НЭГ.ХУУЛЬД ЗААСАН ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРХЭН ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАСАН ТАЛААР ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ**

### ***1.1.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хяналт, шинжилгээ хийх чиг үүргийн хэрэгжилтийн талаар:***

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1.-д “аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, эсхүл тухайн этгээд өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй бүх газарт эрүү шүүлт гарч болзошгүй тогтолцооны шалтгаан, нөхцөлийг судлах зорилгоор тогтмол хяналт шинжилгээ хийх;” гэж заасан байдаг. Уг хуульд энэхүү заалтын “бүх газарт<sup>1</sup>” гэдгийг тодорхой тайлбарласан байдаг.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн нь 2023 онд “шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага”, “цагдаагийн байгууллага”, “ахмад настны асрамжийн газар” болон “хөгжлийн бэрхшээлтэй иргэний асрамжийн газар”, “сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв”-д тус тус хяналт шинжилгээ хийсэн байна. Гэвч 2022 онд “шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага”, “цагдаагийн байгууллага”, “ахмад настны асрамжийн газар” болон “сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв” гэсэн 4 байгууллагад тус тус хяналт шинжилгээг давтан хийсэн нь хуулийн уг заалтад хамаарах “бүх газар”-ыг бүрэн хамруулаагүй байдал дахин давтагдсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 204 дүгээр тогтоолоор баталсан “Хорих байгууллага, түүний нутаг дэвсгэрийн байршил, хорих ангийн дэглэм”-ийн дагуу хаалттай 5, нээлттэй 7, нээлттэй, хаалттай 5 хорих анги, сургалт хүмүүжлийн тусгай байгууллага 1, нэгдсэн болон төрөлжсөн мэргэшлийн хорих эмнэлэг 2, эмэгтэйчүүдийн хорих анги 1, нийт 21 хорих анги, Баривчлах төв, байр тус бүр 1, Нийслэлд цагдан хорих төв 1, орон нутагт 28 цагдан хорих байр, 5 баривчлах байртайгаар ял эдлүүлэх ажиллагаанд холбогдох хууль, журмын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Мөн Монгол Улсад ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний төрөлжсөн асрамжийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг 8, зардлыг хэсэгчлэн санхүүжүүлдэг хувийн хэвшлийн 2, шашны байгууллагын санхүүжилттэй 2, нийт 12 асрамжийн төв үйл ажиллагаа явуулдаг талаар тайланд дурдсан байна.

Харин тайлант хугацаанд “Ховд аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын харьяа Баруун бүсийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нөхөн сэргээх төв”-д хяналт шинжилгээ хийж ажилласан нь хангалтгүй гэж үзэхээр байна.

Хуульд заасан “бүх газарт” гэдэгт хамаарах бусад газар болох хүүхдийн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асрамжийн газар болон сургуулийн дотуур байр, албадан эмчилгээний байр, цэргийн сахилгын байр, хилийн шалган нэвтрүүлэх боомт дахь түр саатуулах болон хамгаалах байруудад эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хяналт шинжилгээ хийж гүйцэтгээгүй нөхцөл байдал хэвээр байгаа бөгөөд эдгээр байршлуудад хяналт шинжилгээ хийгээгүй нөхцөл, шалтгааны талаар тайланд тодорхой зүйл дурдаагүй байна.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасны дагуу “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн нь Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх”-ээр заасан боловч 2022 болон 2023 оны тайланд дурдсан мэдээллээс үзэхэд

---

<sup>1</sup> 33 дугаар зүйлийн 33.1.1-д заасан ... “бүх газарт” гэдэгт хорих байгууллага, цагдан хорих анги, түр болон албадан саатуулах газар, сэтгэцийн эрүүл мэндийн төв, хүүхдийн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн болон ахмадын асрамжийн газар, сургуулийн дотуур байр, албадан эмчилгээний байр, дүрвэгсдийн байр, цэргийн сахилгын байр, хилийн шалган нэвтрүүлэх боомт дахь түр саатуулах болон хамгаалах байрыг ойлгоно.

аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, эсхүл тухайн этгээд өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй бүх газарт бүрэн хүрч ажиллаж чадахгүй байгаа нь хуулийн энэ заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй байх бөгөөд тайлант хугацаанд зохион байгуулсан хяналт шинжилгээний ажил, түүний үр дүнд тулгуурлан өмнөх оны мөн үеэс ахиц гарсан гэж үзэхэд тайланд тусгасан мэдээлэл хангалтгүй байна.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн нь 2022 онд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1-д заасан 4 газарт нийт 23 байршилд хяналт шинжилгээ хийж гүйцэтгэж, нийт 1954 хүнээс асуумж авч, 202 эрх чөлөө нь хязгаарлагдсан хүн, 48 ажилтан, албан хаагчтай ганцаарчилсан ярилцлага хийж байсан бол 2023 онд 5 газарт 47 байршлын хүрээнд хяналт шинжилгээний ажлыг зохион байгуулж, асуумж авч, эрх чөлөө нь хязгаарлагдсан хүн болон ажилтан, албан хаагчтай ганцаарчилсан ярилцлага хийж хяналт шинжилгээний хүрээнд дүгнэлт гаргаж, зохих Зөвлөмжийг хүргүүлэн биелэлтийн хангуулах чиглэлээр ажилласан байна.

Хяналт шинжилгээнд хамрагдсан байгууллагуудаас шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хийсэн хяналт шинжилгээний хүрээнд хорих ангид хорих ял эдэлж байгаа, цагдан хорих байранд хоригдож буй нийт 239 хүнтэй ганцаарчлан уулзаж, 2,552 хүнээс хуульд заасан эрхийн хэрэгжилтийн талаар асуумж авч ажилласан байна. Харин Сэтгэцийн эрүүл мэндийн Үндэсний төвд хийсэн хяналт шинжилгээний хүрээнд 222 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнаас асуумж авч, 34 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтантай ганцаарчлан уулзсан бол тус төвд эмчлүүлж байгаа эмчлүүлэгчдийг хэрхэн хамруулсан талаарх мэдээлэл тайланд тодорхойгүй байна.

Ахмад настны болон хөгжлийн бэрхшээлтэй иргэний асрамжийн газруудад хяналт шинжилгээг зохих аргачлалын дагуу тус асрамжийн газруудын ажилтнууд болон асрамжийн газраар үйлчлүүлж буй асуумж, ярилцлагад оролцох боломжтой гэж үзсэн ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй ярилцлага хийх, асуумж бөглүүлэх зэрэг аргачлалаар явуулсан гэж тайлагнасан боловч түүнд хамрагдсан ажилтан, иргэдийн тоон мэдээлэл тодорхойгүй байна.

Мөн цагдаагийн байгууллагад хийсэн хяналт шинжилгээний хүрээнд асуумж авч, ярилцлагад хамруулсан иргэн, албан хаагчдын талаар тайланд дурдаагүй байх тул энэ чиглэлээр хяналт шинжилгээний ажлыг зохион байгуулаагүй гэж үзлээ.

Хяналт шинжилгээгээр тогтоогдсон нөхцөл байдалд үндэслэн хуульд заасны дагуу Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмж хүргүүлж, зөвлөмжийн хэрэгжилтийг баталгаажуулан ажилласан байна.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг 2023 онд бүрэн хэрэгжүүлэхэд дараах нөхцөл шалтгааны улмаас үр дүнтэй зохион байгуулан ажиллаж чадаагүй талаар тайланд дурдсан байна. Тухайлбал,

1. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн нь үйл ажиллагаагаа хэвийн тогтвортой тасралтгүй явуулахад шаардлагатай хүний нөөц, санхүү, төсөв, тээвэр шатахуун хүрэлцэхгүй байгаа шалтгааныг Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, Төсвийн ерөнхийлөн захирагч, Комиссын Тамгын газрын дарга, Төсвийн шууд захирагчаас төсвийн зарцуулалтын хувьд хараат байдалтай, түүнээс үүдсэн хууль хэрэглээний маргаантай байдал үргэлжилдэг талаар дурдсан байна.
2. “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажиллагааны төсөв нь чиг үүргээ бүрэн, тасралтгүй, үр нөлөөтэй, хараат бусаар эрхлэн явуулахад хүрэлцэхүйц байна.” гэсэн баталгаа хангагдахгүй байгаа талаар дурдаж “өнгөрсөн нэг жилийн хугацаанд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны тусгайлсан төсөв гэж байхгүй, хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд зориулагдсан төсөв хуваарилагдан батлагдаагүйгээс тайлант хугацаанд төлөвлөгдсөн ажлууд бүрэн хэрэгжихгүй тасалдахад хүрч, түүнээс шалтгаалан ажил хэргийн түвшинд үл ойлголцох үндсэн шалтгаан болж ирлээ.” гэсэн байна.

Өөрөөр хэлбэл 2022 онд үйл ажиллагаа явуулахад учирч байсан хүндрэлтэй асуудлууд 2023 онд үргэлжилж, тулгамдсан хэвээр байх бөгөөд өнөөдрийг хүртэлх хугацаанд энэ талаар үр дүнтэй арга хэмжээ авч чадаагүй байдал давтагдаж, Хүний эрхийн Үндэсний Комисс дахь дотоод үл ойлголцлын асуудал шийдвэрлэгдэхгүй байгааг тайланд дурдсан байна.

Тайлант хугацаанд хяналт шинжилгээг дараах байгууллагуудад хийж ажилласан байна. Үүнд:

**1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хийсэн хяналт шинжилгээ:** Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа нийслэлийн Багануур дүүрэг дэх 427 дугаар нээлттэй хорих анги, Төв аймгийн цаашид шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар /ШШГ газар гэх/-ын Мөнгөнморьт сум дахь 417 дугаар нээлттэй, хаалттай анги, Хэнтий аймаг дахь ШШГ газрын Цагдан хорих байр, 419 дүгээр нээлттэй хорих анги, нийслэлийн Баянзүрх дүүрэг дэх 407 дугаар нээлттэй, хаалттай хорих анги, Хөвсгөл аймаг дахь ШШГ газрын Цагдан хорих байр, Булган аймаг дахь ШШГ газрын Цагдан хорих байр, баривчлах байр, 439 дүгээр хаалттай хорих анги, Орхон аймаг дахь ШШГ газрын Цагдан хорих байр, баривчлах байр, 437 дугаар нээлттэй хорих анги, Дархан-Уул аймаг дахь ШШГ газрын Цагдан хорих байр, 445 дугаар нээлттэй хорих анги, Сэлэнгэ аймгийн ШШГ газрын Цагдан хорих байр, Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь ШШГ хэлтсийн 435 дугаар хаалттай хорих анги, Ховд аймаг дахь ШШГ газрын Цагдан хорих байр, 457 дугаар нээлттэй, хаалттай хорих анги, Баян-Өлгий аймаг дахь ШШГ газрын Цагдан хорих байр, Увс аймаг дахь ШШГ газрын Цагдан хорих байр, баривчлах байр, Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь ШШГ хэлтсийн Цагдан хорих байр, 413 дугаар нээлттэй, хаалттай хорих анги, 433 дугаар хаалттай хорих анги, Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь ШШГ хэлтсийн Цагдан хорих байр, 423 дугаар нээлттэй, хаалттай хорих анги, нийслэлийн Баянзүрх дүүрэг дэх Баривчлах төв, 421 дүгээр нээлттэй хорих анги, 441 дүгээр нээлттэй хорих анги, 409 дүгээр хаалттай хорих анги, 405 дугаар хаалттай (тусгай нэгж) хорих анги, Төв аймаг дахь ШШГ газрын Цагдан хорих байр зэрэг байгууллагад;

**2. Цагдаагийн байгууллагад хийсэн хяналт шинжилгээ:** Нийслэлийн цагдаагийн удирдах газрын харьяа Багануур дүүрэг дэх Цагдаагийн газрын Эрүүлжүүлэх, саатуулах байр, Хэнтий аймаг дахь Цагдаагийн газрын Эрүүлжүүлэх, саатуулах байр, Сүхбаатар аймаг дахь Цагдаагийн газрын Эрүүлжүүлэх, саатуулах байр, Хөвсгөл аймаг дахь Цагдаагийн газрын Эрүүлжүүлэх, саатуулах байр, Булган аймаг дахь Цагдаагийн газрын Эрүүлжүүлэх, саатуулах байр, Орхон аймаг дахь Цагдаагийн газрын Эрүүлжүүлэх байр, Сэлэнгэ аймаг дахь Цагдаагийн газрын Эрүүлжүүлэх, саатуулах байр, Дархан-Уул аймаг дахь Цагдаагийн газрын Эрүүлжүүлэх, саатуулах байр, Ховд аймаг дахь Цагдаагийн газрын Эрүүлжүүлэх, саатуулах байр, Баян-Өлгий аймаг дахь Цагдаагийн газрын Эрүүлжүүлэх, саатуулах байр, Увс аймаг дахь Цагдаагийн газрын Эрүүлжүүлэх байр, Сэлэнгэ аймгийн Мандал сумын Сум дундын Цагдаагийн хэлтсийн Эрүүлжүүлэх, саатуулах байр, Төв аймаг дахь Цагдаагийн газрын Эрүүлжүүлэх, саатуулах байр;

**3. Ахмад настны болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асрамжийн газарт хийсэн хяналт шинжилгээ:** Дорнод аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын харьяа Зүүн бүсийн ахмад настны асрамж, үйлчилгээний төв, Дорноговь аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын харьяа Говийн бүсийн ахмад настны төрөлжсөн асрамжийн газар, Ховд аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын харьяа Баруун бүсийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нөхөн сэргээх төв, Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын харьяа Ахмад настны асрамжийн төв, Увс аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын харьяа Баруун бүсийн ахмадын асрамж, үйлчилгээний төв;

**4. Сэтгэцийн эрүүл мэндийн Үндэсний төвд** тус тус хяналт шинжилгээ хийсэн байна.

Тайланд Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь ШШГ хэлтсийн 423 дугаар нээлттэй, хаалттай хорих ангид хяналт шинжилгээ хийж, тогтоогдсон нөхцөл байдлын хүрээнд Эрүү

шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнээс тус хорих ангийн даргад холбогдох Зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Тус нээлттэй, хаалттай хорих ангид хийсэн хяналт шинжилгээгээр “ахуй нөхцөл маш муу, бохир, бие засах газар цөөн мөн маш бохир” нөхцөл байдал тогтоогдсон талаар тайланд дурджээ. Гэтэл 2022 онд тус нээлттэй, хаалттай хорих ангид мөн адил хяналт шинжилгээ хийсэн байх боловч энэ хүрээнд тогтоогдсон нөхцөл байдал, түүний дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар тодорхой тайлагнаагүй байсан нь анхаарал татаж байна.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажлыг Монгол Улсын хэмжээнд хэрэгжүүлэх ёстой боловч 2022 онд ажилласан байгууллагууд дээр дахин очиж хяналт шинжилгээ хийж ажилласан шалтгаан, хяналт шинжилгээний мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээ, явц, гарсан үр дүн тодорхойгүй байгааг мөн адил анхааран үзэх нь зүйтэй байна.

**Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн хяналт шинжилгээгээр тогтоогдсон нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлын талаар товч дурдвал:**

### **1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага:**

Тус байгууллагад 6 чиглэлээр хяналт шинжилгээний ажлыг зохион байгуулж нөхцөл байдалтай танилцахын зэрэгцээ албан хаагчид болон хорих ял эдэлж байгаа, цагдан хоригдож байгаа иргэдтэй ярилцлага, хийж асуумж авч ажилласан байна. Хяналт шинжилгээнээр тогтоогдсон зарим зөрчлүүдээс дурдвал:

- Зарим хорих ангийн байр, хоолны газар болон бие засах газрын эрүүл ахуйн стандарт шаардлага хангагдаагүй;
- Зарим хорих ангийн хоригдол, хорих ангийн алба хаагчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хорих өрөө, хорих анги дотор хоригдол зорчих бусад хэсгийг хамарсан дуу-дүрсний бичлэгийн хяналтыг хэрэгжүүлэх байдал хангалтгүй буюу зарим байршилд камерын хяналтгүй, камерын тусгал муу, чанарын шаардлага хангахгүй, зарим өрөөнд тавигдсан хяналтын камер дахь үзэгдэх орчин хязгаарлагдмал байдалтай;
- Хоригдлуудад үзүүлэх төрөлжсөн эмнэлгийн тусламж үйлчилгээ бүрэн хүрдэггүй, төрөлжсөн мэргэжлийн эмнэлэгт үзүүлэх, эмчлүүлэх боломж хязгаарлагдмал нөхцөл байдалтай;
- Хорих ангид хоригдож байгаа бусад хоригдлуудын зүгээс хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалт тодорхой хэмжээнд байсаар байна;
- Хорих ангид алба хаагч хоригдолтой зүй бусаар харьцаж үзэгдэл тодорхой хэмжээнд байсаар байна;
- Хорих ангийн албан хаагчид албан үүргээ гүйцэтгэхэд гардаг хүндрэл, бэрхшээлүүд байсаар байна. Тухайлбал,
  - ажлын байрны бэлгийн дарамт, ялгаварлан гадуурхалт 2023 онд өссөн үзүүлэлттэй байна;
  - амралтын болон баяр ёслолын үеэр амардаггүй, ажлын илүү цаг, нөхөн олговор авдаггүй байдал өндөр хувьтай хэвээр байна;
  - удирдлага болон хамт ажиллагсад хоригдсон этгээдүүдийн зүгээс хэл амаар доромжлох, гүтгэх, ялгаварлан гадуурхдаг байдал буураагүй байна;
  - ажлын ачаалал их, олон цагаар ажиллуулдаг байдал өндөр хувьтай байна.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хийсэн хяналт шинжилгээгээр тогтоогдсон нөхцөл байдалд үндэслэн эрх бүхий албан тушаалтнуудад Зөвлөмжийг хүргүүлсэн байна.

## **2. Цагдаагийн байгууллага:**

Цагдаагийн байгууллагад хийсэн хяналт шинжилгээний ажил нь тайланд дурдсан мэдээллээс үзэхэд тус байгууллагын эрүүлжүүлэх, түр саатуулах байрны өнөөгийн нөхцөл байдалд хяналт шинжилгээний ажлыг зохион байгуулсан байх бөгөөд харин албан хаагчид болон тус байраар үйлчлүүлж байгаа иргэдтэй ярилцлага хийж, асуумж авч ажилласан талаар тайланд тодорхойгүй байна.

Тус байгууллагад 2022 онд хяналт шинжилгээний ажлыг мөн адил эрүүлжүүлэх, түр саатуулах байрны өнөөгийн нөхцөл байдалд хяналт шинжилгээний ажлыг зохион байгуулсан байх бөгөөд, харин тус байгууллагад ажиллаж байгаа албан хаагчид болон тус эрүүлжүүлэх, түр саатуулах байраар үйлчлүүлж байгаа иргэдээс авсан мэдээлэл, судалгаа, шинжилгээний талаар тайланд тодорхойгүй байсан.

Мөн 2023 онд энэ хүрээнд зохион байгуулсан арга хэмжээ, гарсан үр дүнгийн талаар тайланд тодорхой дурдаагүй байна.

Хяналт шинжилгээгээр илэрсэн нөхцөл байдлын хүрээнд эрүүлжүүлэх байрны нөхцөл, түүнд тавигдах ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага, үйлчлүүлэгчид үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээнд тавих шаардлагыг хангаагүй зэрэг нийтлэг зөрчил тогтоогдсон байна.

Мөн зарим дүүргийн цагдаагийн хэлтсийн хяналтын камерын чиглэлийг зориуд өөрчилсөн, эрүүгийн мөрдөгч нар суух өрөөнд дүрс бичлэгийн камер байршуулаагүй, хэлтсийн дотоод орчныг хянах хяналтын камерууд бүрэн ажиллагаагүй байсан байна. Түүнчлэн Эрүүгийн цагдаагийн тасгийн мөрдөгч нарын байрлах хэсэг болон албаны үйл ажиллагаа явуулах албан өрөөнд дүрс бичлэгийн камер суурилуулаагүй нөхцөл байдал нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь хэсэгт заасан “Халдашгүй чөлөөтэй байх” эрхийг зөрчсөн, гэмт хэрэгт сэрдэгдэн шалгагдаж буй этгээдэд эрүү шүүлт тулгах, түүний бие махбод, сэтгэл санааг шаналган зовоох үйлдлийг хийх орчныг бүрдүүлсэн, камергүй учир эрүү шүүлт тулгах, бие мах бодид хүч хэрэглэх үйлдэл нотлогдохгүй гэх сэтгэлгээг мөрдөгч нарт бий болгосон гэж үзэх нөхцөл байдал илэрсэн талаар тайланд дурджээ.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн нь хяналт шинжилгээгээр тогтоогдсон нөхцөл байдалд үндэслэн эрх бүхий албан тушаалтнуудад зөвлөмж хүргүүлсэн байна.

## **3. Ахмад настны болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асрамжийн газар:**

Хяналт шинжилгээний хүрээнд Дорнод аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын харьяа Зүүн бүсийн ахмад настны асрамж, үйлчилгээний төв, Дорноговь аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын харьяа Говийн бүсийн ахмад настны төрөлжсөн асрамжийн газар, Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын харьяа Ахмад настны асрамжийн төв, Увс аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын харьяа Баруун бүсийн ахмадын асрамж, үйлчилгээний төв зэрэг 4 ахмад настны асрамжийн газар, 1 хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асрамжийн газарт ажилласан байна.

Хяналт шинжилгээний хүрээнд тогтоогдсон нөхцөл байдлаас дурдвал:

- Нийгмийн халамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан асрамжийн үйлчилгээг төрөлжүүлэн явуулахгүй, ихэнх асрамжийн газар нь ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй, байнгын асаргаа шаардлагатай иргэн, хүүхдэд асрамжийн үйлчилгээг хамтад нь үзүүлж байгаагаас асрамжийн газраар үйлчлүүлэгчид болон ажилтан, албан хаагчдын эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа, хүний нэр төрийг доромжлон харьцах, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх зөрчигдөж байна;



- Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асрамжийн газруудын үйл ажиллагаа холбогдох стандартын шаардлагыг бүрэн хангаагүйн зэрэгцээ хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд асрамжийн үйлчилгээ үзүүлэхэд мөрдлөг болгох стандарт, бусад эрх зүйн баримт бичиг хангалтгүй байна;
- Улсын болон орон нутгийн гэсэн хоёрдмол эх үүсвэрээс санхүүжиж байгаагаас зарим асрамжийн газарт санхүүгийн гүйлгээ удаашрах, улмаар өдөр тутмын хэвийн үйл ажиллагаа доголдох эрсдэл үүссэн байна;
- Санхүү, төсвийн хүрэлцээгүй байдлаас шалтгаалан ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ доголдсон байна. Асрамжийн газруудад эм, эмнэлгийн хэрэгслийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны “Зардлын норматив шинэчлэн батлах тухай” А/188 дугаар тушаалаар баталсан “Төрөлжсөн асрамжийн газарт зайлшгүй байх эмийн жагсаалт”-д нийцүүлэн бэлтгэх боломжгүй нөхцөл байдалтай байна;
- Асрамжийн газраар үйлчлүүлэгч ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дийлэнх олонх нь банкны картаа өөрөө эзэмшдэггүй бөгөөд зарим ахмад настан нийгмийн даатгал, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, “насны хишиг”-ийн мөнгийг захиран зарцуулах эрхээ бүрэн эдэлж чадахгүй байна.
- “Хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настанд тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа төрийн үйлчилгээний зарим албан хаагчид хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэл олгох журам”-ын хэрэгжилт хангалтгүйгээс асрамжийн газрын холбогдох албан хаагчид уг журмын дагуу хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэлд хамрагдахгүй байна. Үүнээс улбаалан энэ салбарт ажиллах хүний нөөц хомсдох эрсдэл үүссэн байна;
- Асрамжийн газраар үйлчлүүлж буй бие даан амьдрах чадваргүй, байнгын асаргаа сувилгаа шаардлагатай, сэтгэцийн эмгэгтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг асардаг асрагч нарын ажлын байр, хөдөлмөрлөх эрхийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, түүний үр дүнд үндэслэн холбогдох арга хэмжээ авах шаардлагатай байна.
- Ховд аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын харьяа Баруун бүсийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нөхөн сэргээх төв нь орон нутгийн төсвөөс санхүүждэг бөгөөд санхүүгийн гүйлгээ нь Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын байгууллагын бүртгэлийн дугаараар хийгдэж байгаа нь нөхөн сэргээх төвийн өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулахад бэрхшээл үүсгэж байгаа зэрэг нөхцөл байдлууд ирсэн байна.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн нь хяналт шинжилгээгээр тогтоогдсон нөхцөл байдалд үндэслэн эрх бүхий албан тушаалтнуудад зөвлөмж хүргүүлсэн байна.

#### **4. Сэтгэцийн эрүүл мэндийн Үндэсний төв:**

Хяналт шинжилгээний хүрээнд тус төвийн нөхцөл байдалтай танилцан, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнаас асуумж авч, асуудлуудыг ганцаарчлан ярилцсан бөгөөд зарим эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтантай ганцаарчлан уулзсан байна.

Хяналт шинжилгээний хүрээнд тогтоогдсон нөхцөл байдлаас дурдвал:

- Тус төвд нийгмийн ажилтныг орон тоогоор ажиллуулан, төвд байнга хэвтэн эмчлүүлэгчдийн нийгмийн даатгал, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой судалгаа хийсэн байна. Уг судалгаанаас үзвэл тус төвд байнга байрлан

эмчлүүлдэг нийт сэтгэцийн эмгэгтэй иргэдийн 85.8 орчим хувь нь нийгмийн даатгал, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид хамрагддаг, 43.1 орчим хувь нь нийгмийн даатгал, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн мөнгийг тухайн иргэдийн ар гэр нь авч, зарцуулдаг боловч эмнэлэгт байгаа сэтгэцийн эмгэгтэй хүнийг эргэж ирдэггүй, ямар нэгэн байдлаар санаа тавьдаггүй;

- Тус төвд байнга байрлан эмчлүүлж буй сэтгэцийн эмгэгтэй 17 иргэн нийгмийн даатгал, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид хамрагддаг эсэх нь тодорхойгүй бөгөөд тэдгээр иргэдийн ар гэр, садан, төрлийг олж тогтоох боломжгүй, мөн 7 иргэн бичиг баримтгүй;
- Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилт нэмж авах зорилгоор тус төвд хэвтэн эмчлүүлж буй сэтгэцийн эмгэгтэй иргэдийн өвчний түүхийг хааж, тухайн өвчтөнийг тасагт өвчний түүхгүй, өөрөөр хэлбэл хяналтгүйгээр тодорхой хугацаанд байлган, өвчний түүхийг дахин шинээр нээдэг талаар ганцаарчилсан ярилцлагад оролцсон эмч, мэргэжилтнүүд хэлсэн;
- Өвчний түүхгүй буюу хяналтгүй үед эрүүл мэндийн байгууллагын зүгээс тухайн өвчтөнд ямар нэгэн эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх болон хоол, цайгаар үйлчлэх зохицуулалт байдаггүй бөгөөд энэ үед тухайн сэтгэцийн эмгэгтэй иргэн өөртөө болон бусдад аюултай үйлдэл хийх эрсдэлтэй, энэ тохиолдолд тасагт ажиллаж буй ажилтан хариуцлагыг хүлээдэг зэрэг нөхцөл байдал нь Олон улсын гэрээ, конвенц болон Монгол Улсын холбогдох хуулиар баталгаажсан хүний эрхийг зөрчих эрсдэл, шалтгаан нөхцөл болж болзошгүй байна;
- Тус төвийн клиникүүдэд эмчлүүлж буй эрэгтэй, эмэгтэй эмчлүүлэгчдэд тус тусын цэврийн өрөө хангалтгүй, клиникт ариун цэврийн өрөө байрлах хэсэгт тамхи татах өрөө бий болгон агааржуулалтын системийг шинэчилж, хаалт хийж тусгаарлах арга хэмжээ авч байгаа ч тамхи үнэртсэн хэвээр байх ба үүнээс үүдэн тамхи татдаггүй эмчлүүлэгч болон эмч, ажилтнууд дам тамхидалтад өртөх эрсдэлтэй. Мөн зарим клиникийн усны шугам муудсан учир хэдийгээр урсгал засвар хийсэн ч хананы цаана байрлах шугамаас ус алдсаны улмаас эмчлүүлэгчдийн байрлах хэсгийн хананд хуруугаа хүргэх төдийд ханын будаг, шохой нь үйрэн унаж байв. Үйрч унаж буй будаг, шохойг сэтгэцийн эмгэгтэй хүмүүс идэж хордох зэрэг болзошгүй эрсдэл ажиглагдсан. Эрэгтэй, эмэгтэй эмч, ажилтнууд тус тусын хувцас солих өрөөгүй, шөнийн ээлжид буюу 18 цагаар ажиллах ажилтнуудад хоолоо идэх зориулалтын өрөө, хоол халаах төхөөрөмж хангалтгүй;
- Тус төвийн эмч, эмнэлгийн ажилтнуудтай хийсэн бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагаар ажлын ачаалал их, хэт ачаалалтай олон цагаар ажилладаг, ажил үүрэгтэй холбоотой ямар нэг хадлагад өртөх, эрүүл мэндээрээ хохирох, сэтгэл түгшилт, нойргүйдэл, айдастай эмчлүүлэгчээс болон хамт ажиллагсад, удирдлагын зүгээс хэл амаар доромжилон харьцас заналхийлдэг, гомдол гаргахаар хүлээж авдаггүй, дарамт ирдэг, нийгмийн баталгаа хангалтгүй, ажлын байрны бэлгийн дарамтад өртдөг, ажлын байранд ялгаварлан гадуурхалтад өртдөг, удирдлагынхаа ур чадварыг хангалтгүй гэж үздэг зэрэг асуудлуудыг хэлсэн.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн нь хяналт шинжилгээгээр тогтоогдсон нөхцөл байдалд үндэслэн эрх бүхий албан тушаалтнуудад тус тус зөвлөмж хүргүүлсэн байна.

Хяналт шинжилгээний хүрээнд тогтоогдсон нөхцөл байдал болон гарсан дүгнэлтүүдээс үзэхэд 2022 онд хяналт шинжилгээний хүрээнд тогтоогдсон зарим нөхцөл байдлыг арилгах чиглэлээр ажилласан гэж үзэж болох боловч дийлэнх тогтоогдсон нөхцөл байдлууд агуулгын хувьд давтагдан гарсан хэвээр байгааг анхаарах нь зүйтэй байна.

Тайлангаас үзэхэд 2022 онд хийсэн хяналт шинжилгээний хүрээнд тогтоогдсон зарим асуудлуудыг шийдвэрлэх чиглэлээр гарсан үр дүн, 2023 онд хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн хувьд өмнөх оны мөн үетэй харьцуулахад ямар ахиц дэвшил гарч, ямар үр дүнд хүрсэн талаар тодорхой тусгаагүйгээс эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан зорилтод арга хэмжээнүүд хэрхэн хэрэгжиж, хуулийн зорилгыг хэрхэн хангаж байгаад үнэлэлт, дүгнэлт өгөхөд хүндрэлтэй байна.

**1.2.Олон нийтэд эрүү шүүлтийн хор аюулыг тайлбарлан таниулах, эрүү шүүлтээс ангид байх эрхийг төрийн албан тушаалтан, иргэдэд сурталчлах чиг үүргийн хэрэгжилт:**

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2-т “олон нийтэд эрүү шүүлтийн хор аюулыг тайлбарлан таниулах, эрүү шүүлтээс ангид байх эрхийг төрийн албан тушаалтан, иргэдэд сурталчлах” гэж заасан чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэгж нь иргэд, төрийн байгууллагын холбогдох албан тушаалтнуудад эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрх, эрх чөлөө зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх сургалт, уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж ажилласан байна.

Тайланд “Монгол Улсын ХЭҮКтХ-ийн шинэчилсэн найруулга болон Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколд заасан эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийн мэдлэг олгох, ЭШУС үндэсний ажиллагааг сурталчлах, хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах хандлага төлөвшүүлэх” чиглэлээр 30 удаагийн сургалт, уулзалт, хэлэлцүүлгийг 12 аймаг, нийслэлийн 4 дүүргийн төрийн албан хаагч болон цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, мөн Ахмад настны Үндэсний төвийн албан хаагчид, нийгмийн хамгааллын салбарын төрөлжсөн асрамжийн газрын ажилтнууд, СЭМҮТ-ийн ажилтнууд, хууль зүйн сургуулийн оюутнууд, иргэний нийгмийн байгууллагууд зэрэг 25 удаагийн нийт 3554 албан тушаалтан, ажилтан, алба хаагчдад эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх талаар сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан талаар дурдсан байна.

Мөн эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрх, эрх чөлөөг дэмжих, хамгаалах хүний эрхийн нийт 73 сургагч багшийг бэлтгэн Гэрчилгээ олгосон нь онцлох ажил болжээ.

Эдгээр сургагч багш нар эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрх, эрх чөлөө зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулж, нийт 1304 хүнийг хамруулсан байна.

2022 оны тайланд Ахмад настны Үндэсний төвийн албан хаагчид, нийгмийн хамгааллын салбарын төрөлжсөн асрамжийн газрын ажилтнууд, СЭМҮТ-ийн ажилтнуудад болон иргэний нийгмийн байгууллагуудад хандсан сургалтыг хэрхэн зохион байгуулсан талаар тодорхой тайлагнаагүй байсан бол тайлант онд эдгээр байгууллагуудад зохих сургалтыг зохион байгуулсан талаар дурджээ.

Мөн эрүү шүүлтээс ангид байх эрхийн чиглэлээр төрийн албан хаагчид, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудын алба хаагчид, холбогдох мэргэжилтнүүд, ахмад настны асрамжийн газрын болон түр хамгаалах байрны үйлчлүүлэгч, ажилтнууд, дотуур байрны хүүхдүүд, эрх чөлөөгөө хязгаарлуулсан иргэд, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл нийт 675 иргэн, хуулийн этгээд, тэр дундаа эрүү шүүлт тулгах гэмт хэргийн хохирогч болж болзошгүй эмзэг бүлгийн иргэдтэй ганцаарчилсан уулзалт ярилцлага хийж, хууль эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан байна.

Тайланд зохион байгуулсан сургагч багш бэлтгэх сургалтад хамрагдсан 45 оролцогчоос сургалтын чанар, үр өгөөжийг үнэлэх, цаашид сайжруулах зүйлсийг тодорхойлох зорилгоор асуумж авч дүгнэсэн байна.

Хэдийгээр тайлант хугацаанд тодорхой зарим сэдвээр сургалт, хэлэлцүүлэг, уулзалтыг зохион байгуулж түүний мөрөөр Эрүү шүүлтээс ангид байх хүний эрх зөрчигдсөн талаар иргэн, албан тушаалтнаас ирүүлсэн гомдлын тоо 11 дахин өссөн нь нэг талаасаа иргэд, олон нийтийн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх талаарх хууль эрх зүйн ойлголт нэмэгдэж, зохих мэдээлэлтэй болж байгаа нь тодорхой зарим үр дүнг үзүүлж байгаа мэт боловч энэ нь хүний эрх зөрчигдсөний дараа авч хэрэгжүүлж байгаа алхам байх тул эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх зорилгыг хангаж ажиллахад илүү анхаарч, энэ чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ авч ажиллах нь зүйтэй байна.

Мөн хуульд заасан “бүх газарт” байгаа иргэд, эмчлүүлэгч, үйлчлүүлэгчдэд болон тэдгээрийн ар гэрийнхэнд эрүү шүүлтийн хор аюулын талаарх мэдлэг, мэдээлэл олгох, эрүү шүүлтээс ангид байх эрхээ хамгаалах чадамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн агуулга бүхий сургалтын хөтөлбөр боловсруулах болон сурталчилгаа, танин мэдэхүйн арга хэмжээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээнүүдийг авч ажиллах нь зүйтэй байна.

Хяналт шинжилгээний хүрээнд өмнөх онд буюу 2022 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн зарим арга хэмжээний хэрэгжилтэд шинжилгээ хийхэд 2023 онд эдгээр арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлсэн талаар тайланд тодорхой дурдаагүй байна.

Тухайлбал, сургалтын хөтөлбөрийг Истанбулын протоколд нийцүүлэн боловсруулж, хууль сахиулах байгууллагын албан хаагчдаас гадна эмнэлгийн мэргэжилтэн, бусад холбогдох байгууллагын ажилтнуудыг сургах, сургалтын чанар, хүртээмжийг хөндлөнгийн хараат бус байгууллагаар үнэлгээ хийлгэх чиглэлээр анхаарч ажиллахаар төлөвлөж байгаа талаар дурдсан байх боловч тайлант хугацаанд энэ чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний явц, үр дүнгийн талаар тодорхой тайлагнаагүй байна.

Мөн “зарим байгууллага сургалтын хөтөлбөртөө эрүү шүүлтээс ангид байх эрх, эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх талаарх сургалтыг тусган зохион байгуулсныг эс тооцвол хууль сахиулах байгууллагын давтан сургалтын хөтөлбөрт эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх асуудлыг тусгаж, сургалтыг тогтмолжуулах заалтын хэрэгжилт хангалтгүй, мөн эрүүдэн шүүх асуудлаар хуульч, хууль сахиулагчдыг сургах чиглэлээр алхмууд авч хэрэгжүүлдэг ч бусад мэргэжилтэн, тухайлбал, эмнэлгийн мэргэжилтэн, сэтгэл зүйч, асрамж, халамжийн газрын ажилтнууд, цэргийн анги нэгтгэлийн алба хаагчдад энэ чиглэлийн сургалт зохион байгуулах ажил сул байгаа” талаар дурдаж байсан боловч тайлант хугацаанд энэ чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний явц, үр дүн тодорхойгүй байна.

Мөн сургалтын хөтөлбөрийг боловсруулахдаа судалгаа шинжилгээнд суурилсан зохих агуулгыг тусган боловсруулахад анхаарах шаардлагатай бөгөөд олгож байгаа мэдлэг, мэдээллийн хүртээмж, чанарыг нэмэгдүүлэхэд анхааран ажиллаж, үр дүнг тогтмол тайлагнаж байх нь зүйтэй байна.

### ***1.3.Судалгаа хийх, ном, сургалт, сурталчилгааны хэрэглэгдэхүүн, сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах, хамтын ажиллагааг бэхжүүлэх, хамтран ажиллах чиг үүргийн хэрэгжилт:***

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.3-т “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар судалгаа хийх, ном, сургалт, сурталчилгааны хэрэглэгдэхүүн, сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах зэрэг ажлыг эрхлэн явуулах, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг оролцуулах” чиг үүргийг хэрэгжүүлэхээр заажээ.

Энэхүү чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд “сурталчилгааны хэрэглэгдэхүүн”, “гарын

*авлага боловсруулах*” чиглэлээр Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц, түүний нэмэлт протокол, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг сурталчлан таниулах, түгээх зорилгоор иргэд, олон нийтэд чиглэсэн танилцуулга, видео бэлтгэх, холбогдох гарын авлага боловсруулах ажлыг аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагатай хамтран гүйцэтгэсэн талаар тайлагнасан байна.

Энэ хүрээнд дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулж ажилласан талаар тайланд дурдсан байна. Үүнд:

1. ЭШУС үндэсний ажиллагааны 2022 оны буюу анхдугаар тайланг монгол хэлнээс англи хэл рүү хөрвүүлсэн;
2. Эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийн зөрчлүүд, тэдгээрийн хор аюулыг олон нийтэд таниулсан хүрээнд “Шогч бийр” шог зураачдын холбоотой хамтран ажиллаж, нийт 74 зургийг олон нийтийн хүртээл болгосон;
3. “Соёмбо”, “Хаш тамга” ХХК-ийн төлөөлөлтэй гэрээ байгуулан хамтран ажиллаж, ЭШУС үндэсний ажиллагааны танилцуулгын багцад оруулах сургалтын хэрэглэгдэхүүн (тэмдэглэлийн дэвтэр, бал)-ийг хэвлүүлэн, үйл ажиллагаанд ашиглаж байна;
4. Эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийг сурталчлах, урьдчилан сэргийлэх, эрүү шүүлтийн хор аюулыг төрийн албан тушаалтан, иргэд, олон нийтэд таниулах анимейшн бүтээх зөвлөх үйлчилгээний зарыг тавьж сонгон шалгаруулалтыг хийн, иргэн Ч.Нямсүрэнтэй Ажил гүйцэтгэх гэрээ байгуулан хамтран ажилласан бөгөөд нийт 20 ширхэг бүтээлийг олон нийтэд түгээхэд бэлэн болгосон;
5. ЭШУС үндэсний ажиллагааны танилцуулга нугалбар хуудсыг 2,000 хувь хэвлүүлэн олон нийтэд түгээсэн;
6. “Хуульчийн про боно өдөр-2023” өдөрлөг болон 33 дахь жилдээ зохион байгуулагдсан “Үндэсний номын баяр” арга хэмжээнд оролцож, ЭШУС үндэсний ажиллагаа болон эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийн талаар олон нийт, иргэдэд мэдээлэл өгсөн.

Гэвч дараах арга хэмжээнүүд “сурталчилгааны хэрэглэгдэхүүн” гэсэн ойлголттой хэрхэн нийцэж байгаа нь тодорхойгүй байна. Үүнд:

1. “ЭШУС үндэсний ажиллагааны 2022 оны буюу анхдугаар тайланг монгол хэлнээс англи хэл рүү хөрвүүлж, тайланг нийт 500 хувь хэвлүүлэн, холбогдох олон улсын байгууллага, төрийн албан тушаалтан, иргэдэд хүргүүлсэн;” гэсэн боловч уг тайланг дүгнэлт хэсэгт дурдснаар “дотоод, гадаадын холбогдох талуудад хүргүүлсэн” гэсэн байх бөгөөд харин тайланг “иргэдэд” хэрхэн хүргүүлсэн талаар тодорхойгүй;
2. “Соёмбо”, “Хаш тамга” ХХК-ийн төлөөлөлтэй гэрээ байгуулан хамтран ажиллаж, ЭШУС үндэсний ажиллагааны танилцуулгын багцад оруулах сургалтын хэрэглэгдэхүүн болох тэмдэглэлийн “дэвтэр”, “бал”-ыг хэвлүүлэн, үйл ажиллагаандаа ашигласан нь сурталчилгааны хэрэглэгдэхүүн гэсэн ойлголтод хэрхэн нийцэж байгаа нь тодорхойгүй;
3. “Хуульчийн про боно өдөр-2023” өдөрлөг болон 33 дахь жилдээ зохион байгуулагдсан “Үндэсний номын баяр” арга хэмжээнд оролцож, ЭШУС үндэсний

ажиллагаа болон эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийн талаар олон нийт, иргэдэд мэдээлэл өгсөн.” нь сурталчилгааны ямар хэрэглэгдэхүүнийг боловсруулан уг арга хэмжээнд хэрхэн ашигласан талаар тодорхой дурдаагүй зэрэг болно.

Харин судалгааны хүрээнд Монгол улсын Хүний эрхийн Үндэсний комиссын тухай хуулийн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаатай холбоотой зохицуулалт нь эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц болон түүний нэмэлт протоколд нийцэж байгаа эсэх талаар хуулийн холбогдох зүйлийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ, дүн шинжилгээ хийж, тайланд тусгасан байна.

Өмнөх оны тайланд шинжилгээ хийхэд 2022 онд энэ чиглэлээр боловсруулан гаргасан сурталчилгааны зарим хэрэглэгдэхүүн хуульд заасан зорилгыг хангаж чадсан эсэх болон үр дүн тайланд тодорхойгүй байна.

2022 оны тайланд хяналт шинжилгээ зохион байгуулах албан хаагчдад болон хяналт шинжилгээ явуулах байгууллага, нэгжийн удирдлага, албан хаагч, иргэдэд зориулж “Аливаа хэлбэрээр хүүхдийн эрх, эрх чөлөөг хязгаарлах, эсхүл тухайн хүүхэд өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй төрийн болон төрийн бус байгууллагад хийх хяналт шинжилгээ”, мөн “Аливаа хэлбэрээр хүүхдийн эрх, эрх чөлөөг хязгаарлах, эсхүл тухайн хүүхэд өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй төрийн болон төрийн бус байгууллагад хийх хяналт шинжилгээ” зэрэг гарын авлагуудыг зөвлөх үйлчилгээний хүрээнд боловсруулж хэвлэлтэд бэлтгэсэн талаар дурдаж байсан боловч эдгээр гарын авлагуудыг хэрэглээнд нэвтрүүлсэн эсэх, гарсан үр дүнгийн талаар тайланд тодорхой дурдаагүй байна.

Мөн 2022 оны тайланд “ЭШЭК-ын Нэмэлт протоколыг таниулан сурталчлах, улмаар ЭШУС үндэсний ажиллагааны эрх зүйн зохицуулалт шинэчлэлтийг олон нийтэд сурталчлах зорилгоор 2023 оны 01 дүгээр сарын 30-нд 10-15 минутын танилцуулга, видео бэлтгэх зөвлөх үйлчилгээний зарыг олон нийтэд түгээж “Сартпланет ХХК”-тай гэрээ байгуулан 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдөр танилцуулга видеог хүлээн авч түгээж байна.” гэж тайлагнасан боловч энэхүү контентыг тайлант хугацаанд олон нийтэд хэрхэн хүргэж, ямар үр дүнд хүрсэн талаар тайланд тодорхойгүй байна.

Мөн тайланд тусгасан мэдээллүүдээс дүгнэн үзэхэд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны сурталчилгааны бодлогыг оновчтой болгоход чиглэсэн арга хэмжээг хэрхэн авч хэрэгжүүлсэн талаар мэдээлэл хангалтгүй байх бөгөөд 2022 оны мөн үетэй харьцуулахад ямар ахиц дэвшил гарч, ямар үр дүнд хүрсэн нь тодорхойгүй байна.

Эдгээр сурталчилгааны хэрэглэгдэхүүнүүд нь эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх зорилгыг хангахад хэр хэмжээний үр дүн бүхий нөлөө үзүүлж байгаа нь тодорхойгүй, мөн үр дүнг дүгнэлт хэсэгт ерөнхий байдлаар дүгнэснийг хангалттай гэж үзэх боломжгүй юм.

Цаашид энэ хүрээнд боловсруулан гаргасан сурталчилгааны хэрэглэгдэхүүний үзүүлэх үр дүнд дүн шинжилгээ хийж сайжруулан боловсронгуй болгох чиглэлээр зохих арга хэмжээг авч ажиллах нь зүйтэй байна.

Түүнчлэн “гарын авлага боловсруулах” чиглэлээр тайлант хугацаанд хүний эрхийн сургагч багш бэлтгэх сургалтын хүрээнд гарын авлага боловсруулсан талаар дурдсан байх боловч энэ чиглэлээр тухайлан хийж гүйцэтгэсэн ажлын талаарх мэдээлэл тайланд хангалтгүй байна.

Мөн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хүрээнд “Эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар буюу нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх сэтгэцийн тулгамдсан асуудалтай болон сэтгэцийн эмгэгтэй хүний эрхийг хамгаалах төрийн албан хаагч, хуулийн этгээд, сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг

байгууллага, эмнэлгийн мэргэжилтний үүрэг, гүйцэтгэх үйл ажиллагаанд хийх мониторинг” сэдэвт гарын авлагыг боловсруулж, 500 ширхгийг хэвлүүлсэн бөгөөд үйл ажиллагаандаа ашиглаж байгаа талаар дурдсан нь хуулийн заалтын энэ хэсэгт хэрхэн уялдаж байгаа эсэх тодорхойгүй байна.

Тайланд энэ хүрээнд зохион байгуулсан арга хэмжээний талаарх мэдээлэл хангалтгүй байгаагаас хуулийн энэ заалтын хэрэгжилтийг үнэлхэд хүндрэлтэй байна.

#### **1.4.Хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл, сурталчилгаа тогтмол явуулах чиг үүргийн хэрэгжилт:**

Тайлант хугацаанд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг хэрэгжүүлсэн талаарх мэдээ мэдээллийг өөрийн олон нийтийн сүлжээний “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа” пэйж хуудас болон ХЭҮК-ын албан ёсны цахим хуудас, мөн олон нийтийн сүлжээ, хандалт ихтэй мэдээ, мэдээллийн сайтуудаар түгээсэн байна.

Мөн хорих ангид хоригдож буй зарим иргэдийг хамруулан түүний дүрс бүхий ярилцлагыг бэлтгэн, хэвлэлийн хурал зохион байгуулсан болон Эрүү шүүлтийн хохирогчдод дэмжлэг үзүүлэх олон улсын өдрийг тохиолдуулан “Эрүү шүүлтгүй Монголын төлөө” зөвлөлдөх уулзалтыг холбогдох төрийн эрх бүхий байгууллага, мөн олон улсын байгууллагын төлөөлөл болон эрх чөлөөгөө хязгаарлуулж, хорих ял эдэлж байсан хоёр иргэнийг хамруулан зохион байгуулан тус зөвлөлдөх уулзалтын талаарх мэдээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэсэн байна.

Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын танилцуулга, эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрх, эрх чөлөөг төрийн албан тушаалтан, олон нийтэд таниулан сурталчилсан нийт 90 удаагийн мэдээ, мэдээлэл, 40 ширхэг зурагт хуудас, “Конвенцыг кодольт” сэдэвт Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын танилцуулгын 36 зурагт хуудас бэлтгэн ЭШУС үндэсний ажиллагааны цахим хуудас, ХЭҮК-ын албан ёсны цахим хуудас, твиттер зэрэг олон нийтийн мэдээллийн сүлжээгээр түгээсэн бөгөөд энэхүү тоон мэдээллийг ЭШУС үндэсний ажиллагааны 2022 оны тоон мэдээлэлтэй харьцуулахад даруй дөрөв дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна гэж тайланд дурдсан байна.

Хэдийгээр энэхүү үзүүлэлт нь 2022 онтой харьцуулахад өссөн боловч зохион байгуулсан арга хэмжээний чанар, түүний нийгэмд үзүүлэх үр нөлөө хэрхэн өсөж, ямар үр дүнд хүрсэн нь тодорхойгүй буюу эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан зохион байгуулсан мэдээлэл, сурталчилгааны арга хэмжээнүүдийг хангалттай хэрэгжсэн гэж дүгнэх боломжгүй байна.

Тухайлбал, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн өөрийн биеэр Монголын Үндэсний Олон Нийтийн телевиз болон бусад телевизэд ярилцлага өгсөн, хорих ангид хоригдож буй зарим иргэдийг хамруулан түүний дүрс бүхий ярилцлага бэлтгэн, хэвлэлийн бага хурал зохион байгуулан хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэсэн зэрэг арга хэмжээнүүдийг үр дүнтэй гэж үзэхэд учир дутагдалтай байна.

Тайланд дурдсан мэдээллийг нягтлан үзэхэд 2023 онд хэрэгжилт хангалтгүй байгаа шалтгааныг “сургалт, сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагааг тогтмол давтамжтай, тасралтгүй явуулахад шаардагдах хүний нөөц, санхүү, төсөв, тээвэр шатахуун хүрэлцэхгүй байгаа” гэж тайлбарлаж, тайланд дурдсан байх бөгөөд уг хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнгийн талаарх тодорхой мэдээлэл байхгүй байна.

Цаашид эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны ажлын чанар, хүртээмж, нийгэмд үзүүлж байгаа үр нөлөөг нэмэгдүүлэхэд чиглэсэн цогц бодлого боловсруулан хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

**• Ашгийн төлөө бус хуулийн этгээд болон бусад байгууллагатай хамтран ажилласан талаар:**

Энэ хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулан ажилласан талаар тайланд дурдсан байна. Үүнд:

1. Эрүү шүүлтийн хохирогчдод дэмжлэг үзүүлэх олон улсын өдрийг тохиолдуулан “Эрүү шүүлтгүй Монголын төлөө” сэдэвт зөвлөлдөх уулзалт, хэлэлцүүлгийг НҮБ, ХЭҮК, ХЭХҮХ, ШЕЗ, ЗХЖШ, ХХЕГ, АТГ, ТЕГ, УЕПГ, ЦЕГ, ШШГЕГ, ГИХГ, ШШЕГ, ХНХЯ, АНҮТ, СЭМҮТ, Монгол Улсын Их сургууль, Дотоод хэргийн их сургууль, Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, “Эмнести интернэшнл” олон улсын байгууллагын төлөөллийг хамруулан зохион байгуулсан;
2. “Шогч бийр” шог зураачдын холбоотой хамтран ажиллаж эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийн зөрчлүүд, тэдгээрийн хор аюулыг олон нийтэд таниулсан 74 гар зургийн үзэсгэлэнг гаргаж, Хүүхдийн урлан бүтээх төвийн үзэсгэлэнгийн танхимд 14 хоногийн турш олон нийтэд дэлгэж танилцуулсан;
3. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Нэг тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд мод тарих дэлхийн өдөр ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн, ЭШУС хэлтсийн хамт олон мод тарьж, байгаль дэлхийгээ нөхөн сэргээх үйлсэд хувь нэмрээ оруулав;
4. ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн ЦЕГ-ын Мөрдөн байцаах албаны дарга, цагдаагийн хурандаа Н.Мишигдорж болон даргын зөвлөлийн гишүүдтэй уулзаж, цагдаагийн байгууллагад шалгагдсан зарим хэргүүдэд хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн эсэх асуудлаар холбогдох мэдээллийг авч, эрүү шүүлттэй холбоотой гэмт хэрэг, зөрчлийн өнөөгийн нөхцөл байдал, эрүү шүүлт тулгах гэмт хэрэгтэй тэмцэхэд тус албаны удирдлага, алба хаагчдын манлайлал, үүрэг, хариуцлага, олны анхаарал татаж буй зарим хэргийн талаарх мэдээллийг хууль, журмын хүрээнд иргэд, олон нийтэд хүргэх, олон улсын гэрээ, үндэсний хууль тогтоомжид заасан эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийн хэрэгжилтийг хангахад мөрдөгчдийн мэдлэг, мэргэшлийн ур чадвар, харилцааны соёлыг дээшлүүлэх хэрэгцээ, шаардлагын талаар санал солилцсон;
5. “Хуульчийн про боно өдөр-2023” өдөрлөг болон 33 дахь жилдээ зохион байгуулагдсан “Үндэсний номын баяр” арга хэмжээнд оролцож, ЭШУС үндэсний ажиллагаа болон эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийн талаар олон нийт, иргэдэд мэдээлэл өгсөн;
6. Баянгол дүүргийн Прокурорын газраас зохион байгуулсан “Эрүү шүүлт болон эрүү шүүлт тулгах аливаа хэлбэрээс урьдчилан сэргийлэх, ангид байх” сэдэвт уулзалтад ЭШУС хэлтсийн албан хаагчид ЭШУС үндэсний ажиллагааны талаар танилцуулга хийж, “Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн хэрэгжилт” сэдвээр сургалт явуулсан. Сургалтад Баянгол дүүргийн Прокурорын газрын прокурор, ажилтнууд, тус дүүргийн Цагдаагийн газрын Эрүүгийн цагдаагийн болон Мөрдөн байцаах тасгийн мөрдөгчид оролцсон;
7. ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний санаачилгаар Олон улсын ахмадын өдрийг тохиолдуулан Төв аймгийн Батсүмбэр сум дахь АНҮТ-өөр үйлчлүүлэгч ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүндэтгэл үзүүлэн, өдөрлөг зохион



байгуулсан бөгөөд уг өдөрлөгт ЭШУС үндэсний ажиллагааны албан хаагчид оролцсон;

8. НҮБ-ын Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 75 жилийн ойг тохиолдуулан ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн, хууль зүйн доктор Я.Цэлмэн Их засаг Чингис Соосэ олон улсын харилцааны сургуулийн удирдлага, багш, оюутнуудын урилгаар тус сургуульд зочилж “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа”, “Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.12 дугаар зүйл. Эрүү шүүлт тулгах” сэдвүүдийн хүрээнд ЭШУС үндэсний ажиллагааг танилцуулан, эрүү шүүлт тулгах гэмт хэргийн ойлголт, урьдчилан сэргийлэх асуудлаар сургалт явуулсан зэрэг болно.

Тайланд шинжилгээ хийхэд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний зүгээс хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд авч хэрэгжүүлсэн “Нэг тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд мод тарих дэлхийн өдөр ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн, ЭШУС хэлтсийн хамт олон мод тарьж, байгаль дэлхийгээ нөхөн сэргээх үйлсэд хувь нэмрээ оруулав.” гэсэн нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Үндэсний ажиллагааны зорилготой хэрхэн уялдаж байгаа нь тодорхойгүй байна.

Мөн 2022 оны тайланд “НҮБ-ын ЭШУС Дэд хороотой хамтран ажиллахаас гадна НҮБ-ын хүний эрхийн тогтолцоонд хамаарах бусад байгууллагатай уялдаатай ажиллахаар төлөвлөж байна.” гэж тайлагнасан байх бөгөөд энэ хүрээнд тайлант онд холбогдох уулзалт, бага хурал, бүсийн уулзалтуудад оролцсон боловч үр дүнг тодорхой тайлагнаагүй байна.

Олон улсын болон бусад урьдчилан сэргийлэх Үндэсний ажиллагаатай хамтран ажиллах хүрээнд Монгол Улсын ЭШУС үндэсний ажиллагаанаас хамтран ажиллах боломжтой олон улсын байгууллагуудын мэдээллийн санг үүсгэн, хамтын ажиллагааны чиглэлээ тодорхойлсон бөгөөд харилцан туршлага солилцох, ЭШУС цогц арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх шинэлэг арга барилаас судлах, нутагшуулах зорилгоор зарим Улсуудын эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаатай хамтын ажиллагаа тогтоон ажиллаж байгаа талаар тайланд дурдсан байна.

Харин 2022 оны тайланд “ЭШУС үндэсний ажиллагааны хүрээнд олон улсын байгууллага, нийгэмлэг, сүлжээ байгууллагуудтай харилцан уялдаатай хамтын ажиллагааг хөгжүүлэхийг хүрээнд Олон улсын хүний эрхийн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг /*Association for the Prevention of Torture*/, Эрүү шүүлтийн эсрэг санаачилга /*Anti-Torture Initiative*/ зэрэг байгууллагуудтай болон ашгийн төлөө бус “Монголын Эмнести Интернэшнл” ОУБ, “Монголын ЛГБТ төв” ТББ, Дундговь аймаг дахь “Ид шидийн орон төсөл”-ийн багийнхантай хамтын ажиллагаа эхлүүлж байгаа” талаар дурдсан байх боловч тайланд эдгээр байгууллагуудтай хэрхэн хамтарч ажилласан, хамтын ажиллагааны хүрээнд гарсан үр дүнгийн талаар тодорхой дурдаагүй байна.

Тайланд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар судалгаа хийх, ном, товхимол боловсруулах чиг үүргийн хүрээнд тайлант хугацаанд хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар тодорхой дурдаагүй байдал давтагдан гарсан байна.

**1.5.Иргэн, албан тушаалтнаас ирүүлсэн эрүү шүүлтээс ангид байх эрх зөрчигдсөн талаарх гомдол, мэдээллийг холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлсэн талаар:**

ЭШУС үндэсний ажиллагааны хүрээнд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнд хандаж иргэд, хуулийн этгээдээс эрүү шүүлтээс ангид байх хүний эрх зөрчигдсөн талаарх нийт 66 гомдол, мэдээлэл ирүүлсэн нь өнгөрсөн жилтэй харьцуулахад 94,6 хувиар буюу 11 дахин өссөн талаар тайланд дурдсан байна.

Иргэд, хуулийн этгээдээс ирүүлсэн тэдгээр гомдол, мэдээллийг хүлээн авч танилцан, эрх нь зөрчигдсөн гэх 19 иргэнтэй биечлэн уулзаж эрх зүйн туслалцаа үзүүлэн, зарим санал, хүсэлтийг эрх бүхий албан тушаалтнаар даруй шийдвэрлүүлэн, гомдлыг шалган шийдвэрлэх

эрх бүхий байгууллага, албан тушаалтнуудад зохих хугацаанд нь албан бичгээр шилжүүлсэн байна. Үүнд:

- УЕПГ-т болон холбогдох албан тушаалтанд 15;
- ШШГЕГ-т болон харьяа газрын холбогдох албан тушаалтанд 13;
- АТГ-ын холбогдох албан тушаалтанд 12;
- ЦЕГ болон харьяа хэлтэст 2;
- Шүүхийн сахилгын хороонд 1;
- ХЗДХЯ-ны харьяа Хууль зүйн туслалцааны төвд 1 гомдол, мэдээллийг тус тус шилжүүлсэн байна.

Иргэд, хуулийн этгээдээс ирүүлсэн гомдол, хүсэлтийг эрхийн төрлөөр ангилбал:

1. Халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй холбоотой 27 гомдол, хүсэлт байна. Үүнээс хамгийн их 10 буюу 37.0 хувийг “Хорих ангийн алба хаагч эрүү шүүлт тулгасан”-тай холбоотой гомдол, хүсэлт эзэлж байна.
2. Шударга шүүхээр шүүлгэх эрхтэй холбоотой 26 гомдол, хүсэлт байна. Үүнээс хамгийн их 11 буюу 42.3 хувийг “нотлох баримт шалгуулах, шүүхэд нэхэмжлэл гаргах”-тай холбоотой гомдол, хүсэлт эзэлж байна.
3. Ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхтэй холбоотой 5 гомдол, хүсэлт байна. Эдгээр 5 гомдол, хүсэлт нь “үндэс, угсаа, хэл, арьс өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, нийгмийн байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, бэлгийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн байдал, холбогдсон зүйл ангиар ялгаварлан гадуурхагдсан”-тай холбоотой гомдол, хүсэлт байна.
4. Харин 8 гомдол, хүсэлт биечлэн уулзаж хууль зүйн зөвлөгөө авахтай холбоотой байна.

Иргэн, албан тушаалтнаас ирүүлсэн гомдол мэдээллийг эрх бүхий албан тушаалтанд шилжүүлэн ажилласан талаарх мэдээллийг тайланд тусгасан байх боловч тэдгээр гомдол, хүсэлт хэрхэн шийдвэрлэгдэж, түүний дагуу авсан арга хэмжээ, гарсан үр дүнгийн талаарх мэдээлэл тайланд тодорхойгүй байна.

**• Эрүү шүүлт тулгах, хууль бусаар баривчлах, ялгаварлан гадуурхах гэмт хэргүүдийн тухай гомдол мэдээлэл, түүний шийдвэрлэлт:**

2023 онд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.9 буюу “хууль бусаар баривчлах”, 14.1 буюу “ялгаварлан гадуурхах”, 21.12 буюу “эрүү шүүлт тулгах” гэмт хэргийн шинжтэй бүртгэгдсэн 87 гомдол, мэдээллийн 64 гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан, 20 гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн, 3 гомдол, мэдээлэлд Эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татсан байна. Үүнд:

- ЭХ-ийн тусгай ангийн 13.9 дүгээр зүйл буюу “хууль бусаар баривчлах, саатуулах” гэмт хэрэгт цагдаагийн алба хаагч холбогдсон 5 гомдол, мэдээлэл шалгагдсанаас 4 гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 1 хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна;
- ЭХ-ийн тусгай ангийн 14.1 дүгээр зүйл буюу “ялгаварлан гадуурхах” гэмт хэрэгт алба хаагч холбогдсон талаарх гомдол, мэдээлэл 2023 онд ирээгүй байна;
- ЭХ-ийн тусгай ангийн 21.12 дугаар зүйл буюу “эрүү шүүлт тулгах” гэмт хэрэгт 16 цагдаагийн алба хаагч, төрийн 2 албан хаагч холбогдсон нийт 82 гомдол, мэдээлэл шалгагдсанаас 15 цагдаагийн алба хаагчид холбогдох 64 гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 15 хэрэг бүртгэлтийн хэрэг

нээж, 3 алба хаагчид эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татаж, 2 алба хаагчид холбогдох хэргийг шүүхэд шилжүүлэн, 1 алба хаагчид холбогдох эрүүгийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.

- Иргэд, хуулийн этгээдээс 2017 оны эхний хагас жилд 5 гомдол, мэдээлэлд 5; 2018 онд 33 гомдол, мэдээлэлд 47; 2019 онд 74 гомдол, мэдээлэлд 96; 2020 онд 86 гомдол, мэдээлэлд 115; 2021 онд 86 гомдол, мэдээлэлд 99; 2022 онд 75 гомдол, мэдээлэлд 87, 2023 онд 87 гомдол, мэдээлэлд 23 цагдаагийн алба хаагчийг тус тус холбогдуулан гомдол, мэдээлэл ирүүлсэн байна.
- ШЕЗ-ийн Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгээс ирүүлсэн мэдээлэлд 2017, 2018 онд 2002 оны ЭХ-ийн 251 дүгээр зүйл, 2015 оны ЭХ-ийн 21.12 дугаар зүйл (эрүү шүүлт тулгах)-ээр хэрэг хянан шийдвэрлэгдээгүй, харин 2019 онд 2, 2020 онд 2, 2021 онд 3, 2022 онд 3, 2023 онд 2 хэрэг шийдвэрлэгдсэн талаар тайланд дурджээ.

### **ХОЁР.ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ГИШҮҮНИЙ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ**

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-д "... байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдийн шийдвэр, үйл ажиллагаа нь эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар шийтгэх буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж болзошгүй гэж үзвэл шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар холбогдох байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдэд зөвлөмж хүргүүлнэ." гэж заасан.

Энэ хүрээнд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн хяналт, шинжилгээний явцад тогтоогдсон нөхцөл байдалд үндэслэн **нийт 25 зөвлөмжийг** холбогдох албан тушаалтанд хүргүүлснээс Засгийн газрын гишүүдэд давхардсан тоогоор 3 удаа, прокурорын байгууллагын удирдах албан тушаалтанд 1, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын удирдах албан тушаалтанд 18, цагдаагийн байгууллагын удирдах албан тушаалтанд 2, бусад төрийн байгууллагын удирдах албан тушаалтанд 1 удаа тус тус зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2-т "Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийг хүлээн авсан байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд заавал биелүүлэх үүрэгтэй" гэж, мөн зүйлийн 35.3-т "Байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд нь зөвлөмжийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хэрэгжүүлсэн талаар бичгээр хариуг мэдэгдэнэ." гэж заасан.

Тайланд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнээс хүргүүлсэн зөвлөмжийн дагуу холбогдох албан тушаалтнууд зохих хариуг ирүүлсэн талаар дурдсан боловч Зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний явц, үр дүнд хийсэн дүн шинжилгээг нарийвчлан тусгаагүй байна.

### **ГУРАВ.ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**

Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.3 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын Тамгын газраас Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2023 оны тайланд шинжилгээ хийлээ.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа 2023 онд дараах үр дүнд хүрсэн байна:

1. Тайлант хугацаанд зохион байгуулсан Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хүрсэн үр дүн, үйл ажиллагааны ахиц дэвшлийн талаар шинжилгээ хийж дүгнэхэд шаардлагатай мэдээлэл хангалтгүй байлаа;
2. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, санхүү, төсөвтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх чиглэлээр Хүний эрхийн Үндэсний Комисс дотор үүссэн дотоод үл ойлголцол тайлант хугацаанд мөн адил үргэлжилсэн хэвээр байна. Өөрөө хэлбэл 2023 онд уг асуудлыг шийдвэрлэх хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар тодорхойгүй байна;
3. Эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрх, эрх чөлөөг дэмжих, хамгаалах хүний эрхийн нийт 73 сургагч багшийг бэлтгэн Гэрчилгээ олгосон нь онцлох ажил болжээ.
4. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн нь 2022 онд хуульд заасан “бүх газарт” хяналт шинжилгээг бүрэн хийгээгүй дутагдал тайлант хугацаанд дахин давтагдсан байна. Өөрөө хэлбэл хүүхдийн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асрамжийн газар болон сургуулийн дотуур байр, албадан эмчилгээний байр, цэргийн сахилгын байр, хилийн шалган нэвтрүүлэх боомт дахь түр саатуулах болон хамгаалах байруудад эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй байна. Мөн 2022 онд хяналт шинжилгээ хийсэн байгууллагуудад 2023 онд ямар үр дүн гарсан нь тодорхойгүй байх бөгөөд хяналт шинжилгээ хийсний үндсэн дээр дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг бодитой тодорхойлох ажил хийгдээгүй гэж үзэхээр байна. Зөвхөн хяналт шинжилгээний хүрээнд зөвлөмж хүргүүлэх байдлаар ажилласан байна;
5. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн нь цагдаагийн байгууллагын эрүүлжүүлэх, түр саатуулах байрны нөхцөл байдалд хяналт шинжилгээ хийсэн байх бөгөөд харин тэдгээр байранд ажиллаж байгаа албан хаагчид болон үйлчлүүлж байгаа иргэдтэй ганцаарчилсан ярилцлага хийж, асуумж авах зэрэг аргачлалаар хийсэн судалгаа, шинжилгээний талаар тодорхой тусгаагүй байдал тайлант хугацаанд дахин давтагдсан байна;
6. Тайланд 2022 онд хэрэгжүүлэхээр төлөвлөн бэлтгэл хангаж байсан зарим арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлж, ямар үр дүнд хүрсэн талаар тодорхой тусгаагүй байна;
7. Хяналт шинжилгээний хүрээнд зохих зөвлөмжийг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж, биелэлтийг тодорхой хэмжээнд хангуулан ажиллаж байгаа ч хяналт шинжилгээгээр тогтоогдсон зөрчилтэй нөхцөл байдлууд давтагдан гарсаар байна.
8. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа мэдээлэл, сурталчилгааны ажлын бодлого, чанар хүртээмж, үр дүн хангалтгүй байна.
9. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар судалгаа хийх, ном, сургалт, сурталчилгааны хэрэглэгдэхүүн, сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх мэдээлэл хангалтгүй буюу тайланд тодорхойгүй, нарийвчлан тусгаагүй байдал дахин давтагдсан байна.

## ЗӨВЛӨМЖ

Шинжилгээний үр дүнд тулгуурлан Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах хүрээнд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний хуульд заасан чиг үүргийн хэрэгжилт, түүний үр дүнг дээшлүүлэхэд чиглэсэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Хүний эрхийн Үндэсний Комисс дотор үүсээд байгаа дотоод үл ойлголцол, ажлын уялдаа холбоогүй байдлыг шийдвэрлэх чиглэлээр арга хэмжээ авч, үр дүнг 2024 оны тайланд тусгах;
2. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 33 дугаар зүйлд заасан чиг үүргийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, үр дүнд суурилсан төлөвлөлт хийж, чанар хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч, явц, үр дүнд дүн шинжилгээ хийж ажиллах;
3. Эрүү шүүлт, ялангуяа, эрүүдэн шүүх, хууль бусаар баривчлах, хууль бусаар цагдан хорихтой холбоотой иргэн, албан тушаалтны гомдол, мэдээллийг шалган шийдвэрлэхэд анхаарч, гарсан үр дүнг тайланд тусгаж хэвших;
4. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний явц, үр дүнд тогтмол дүн шинжилгээ хийж, энэ талаар тайланд тусгах;
5. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, эсхүл тухайн этгээд өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй бүх газар гэдэгт хамаарах хүүхдийн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асрамжийн газар, сургуулийн дотуур байр, албадан эмчилгээний байр, цэргийн сахилгын байр, хилийн шалган нэвтрүүлэх боомт дахь түр саатуулах байруудад тогтмол хяналт тавьж ажиллах талаар шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах. Өөрөөр хэлбэл 2022-2023 онд хийсэн хяналт шинжилгээний мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар тайланд тусгах, цаашид Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1-д заасан бүх газарт хяналт шинжилгээг хийн гарсан дүнд дүн шинжилгээ хийж тайланд тусгах;
6. Цагдаагийн байгууллагад хийх хяналт шинжилгээний хүрээнд эрүүлжүүлэх, түр саатуулах байранд ажиллаж байгаа албан хаагчид болон түүгээр үйлчлүүлж байгаа иргэдтэй ганцаарчилсан ярилцлага хийж, асуумж бөглүүлэх зэрэг аргачлалаар судалгаа хийж, дүнг тайланд тусгах;
7. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиг үүргийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны ажлын чанар, хүртээмж, түүний нийгэмд үзүүлэх үр нөлөөг нэмэгдүүлэхэд чиглэсэн цогц бодлого бүхий арга хэмжээг зохион байгуулан хэрэгжүүлж, гүйцэтгэлд дүн шинжилгээ хийн тайланд тусгах;
8. Хүний эрхийн Үндэсний комиссын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д заасан хүрээнд гэмт хэргийн нөхцөл байдал, түүний шалтгаан, нөхцөлийн талаар статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийж тайланд тусгаж хэвших;
9. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн хяналт шинжилгээний хүрээнд тогтоогдсон нөхцөл байдлыг шат дараатайгаар арилгахад чиглэсэн зохих арга хэмжээг эрх бүхий байгууллагатай хамтран зохион байгуулж, шаардлагатай тохиолдолд явцын хяналт шинжилгээ хийх;

10. Цаашид тайланг эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын явц, байдлын талаар биш үр дүнд суурилсан, нарийвчилсан дүн шинжилгээ хийж дүгнэсэн байдлаар боловсруулан ирүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.

--- оОо ---